



ТӨВ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор

Т.Майцэцэг

Утас: 70273204 99018619

И-Мэйл: maits2009@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ТӨВ-2017/8/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай болон нийцлийн аудит 4200-р стандарттай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дүгээр сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дугаар сарын 25-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 22-нд Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн шууд захирагч нь Монгол улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д Энэ хуулийн зорилт нь Засгийн газрын агентлаг /цаашид "агентлаг" гэх/-ийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12.1-д "агентлагийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ" гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д "төсвийн шууд захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг" 16 дугаар зүйлийн 16.4.18-д төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна гэж заасны дагуу Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн шууд захирагчийн төсвийг МХЕГ-аас баталж Төв аймгийн төрийн сангаар олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Шилэн дансны тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиуд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Мэргэжлийн хяналтын газрын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын 10 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн emerald программ уялдсан байна.

Төсвийн шууд захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж хянахад Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй. ҮСХорооны дотоод аудит хяналт шинжилгээ үнэлгээний газраас хяналт шалгалт хийгдээгүй байна. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Мэргэжлийн хяналтын газрын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 536814.7 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулахаар төсөв батлагдсан, гүйцэтгэлээр улсын төсвөөс 536814.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулаагүй үлдэгдэл 3242.6 мянган төгрөгийг татан төвлөрүүлснийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулгаар тайлагнасан.

Өөрийн орлогоор 3000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 5437.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Өөрийн орлогыг дээд шатны төсөвт төвлөрүүлэхээс 2184.3 мянган төгрөгийг МХЕГазрын даргын 2016.09.16-ний өдрийн 1/2454 тоот албан бичгээр хүргүүлсэн төсөв санхүүгийн хүндрэл нөхцөл байдлаас үүсч болох эрсдэл, Төсвийн сахилга хариуцлагыг чангатгах тухай хүрээнд өрийн асуудлыг төсвийн хүрээнд аймгийн СТСХэлтсээр боломжтой зардлаас зохицуулалт хийлгэж зарцуулахыг мэдэгдсний дагуу нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2015 оноос “shilendans.gov.mn” цахим сайтад зохих мэдээллийг оруулсан. ҮАГ-аас нэгдсэн удирдамжаар 2016 оны 10-р сарын байдлаар хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар тус байгууллага нь нийт 22 мэдээлэл байршуулахаас 17 мэдээллийг байршуулж, 5 мэдээлэл байршуулаагүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн үе шатанд 10 горим, нарийвчилсан сорилыг хийж гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Цалингийн урьдчилгааг бүрэн суутгасан эсэхийг шалгахад цалингийн цэсэнд болон цалинг банк руу олгосон жагсаалтанд ажиллагсдаар гарын үсэг огт зуруулаагүй. Гарт олгох цалингаас 5.0-65.0 мянган төгрөгийг ажиллагсадаас янз бүрийн дүнгээр суутган нийт 5185.0 мянган төгрөгийг Д.Оюунчимэгийн дансанд хуримтлал шилжүүлсэн мөн 12-р сард 2 хүний дансанд 699.7 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн. 2-р сард Д.Батсайханы гарт олгох цалингаас 200.0 мянган төгрөг суутган ня-бо өөрийн харилцах дансанд 195.0 мянган төгрөгийг нэмж шилжүүлсэн, 7-р сарын цалин банк руу олгох жагсаалтаар 320.8 мянган төгрөгийг нэр дансны дугаар байхгүйгээр шилжүүлсэн. Ня-бо 7-р сард цалингийн бусад нэмэгдэл нэрээр 837.5 мянган төгрөгийн урьдчилгааг авсан. НББ-ийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1-д Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 20.1.1. нягтлан бодох бүртгэлийн анхан

шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах; 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Дээрх 6543.3 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, цалингийн цэс болон цалинг банк руу олгосон жагсаалтанд ажиллагсдаар гарын үсэг зуруулж, цалингаас суутгах суутгалыг цалингийн суутгал хэсэгт суутган тооцоо үүсгэн бүртгэж байх зөвлөмж өгөв

2. Шатахуун, Тусгай зориулалттай материал, бичиг хэргийн дансанд түүвэрлэн хяналтын тооллого хийлээ. Тооллогоор 120.0 мянган төгрөгийн шатахууны талон дутагдсан нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, НББ-ийн тухай хуулийн 12.4-д Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ, Санхүүгийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн: Биет тооллогоор дутагдсан 120.0 мянган төгрөгийн шатахууны талоны үнийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Тайлант оны үндсэн үйл ажиллагааны орлого 5437.4 мянган төгрөгийн орлогоос 3253.1 мянган төгрөгийг 9...773 тоот дансанд төвлөрүүлсэн ба 2184.3 мянган төгрөгийг 2016.11.10-ний өдөр ямар ч шийдвэргүйгээр нэмэлт санхүүжилтийн дансандаа төвлөрүүлэн зарцуулсан Төсвийн тухай хуулийн 47-р зүйлийн 47.1.1-47.1.6 дах заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад тайлбарыг МХЕГазраас ирүүлсэн.

4. Эм боох материалын эхний үлдэгдэл санхүүгийн тайланд 4071.3 мянган төгрөг, лабораторийн эрхлэгч Б.Хишигтогтохийн хийсэн тайлангаарх эхний үлдэгдэл 8370.5 мянган төгрөг буюу 4299.2 мянган төгрөгөөр зөрүүтэй, эхний үлдэгдлийг залруулахдаа орлого зарлагын гүйлгээг 4980.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. Хоолны зардлын 1591.2 мянган төгрөгийн гүйлгээг бараа материал дансанд тайлагнаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. гэж заасантай болон Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.7.байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах; гэ заасантай нийцэхгүй байна. Санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Алдааг хүлээн зөвшөөрч аудитын явцад залруулсан.

5. Үндсэн хөрөнгийн тайлан гаргаагүй, ҮХ маягт болон анхан шатны баримт байхгүй хөтлөөгүйгээр ня-бо санхүүгийн программд баримтыг үндэслэн нэмэгдсэн хасагдсан хөрөнгийн гүйлгээг шивсэн. Аймгийн ИТХТ-ийн 2016.12.22-ний өдрийн 66-р тогтоолын хэрэгжилтийг тулган шалгахад дуудлага худалдаа сонгон шалгаруулалт явуулах худалдах доод үнийг 1000.0 мянган төгрөгөөр тогтоосныг хэрэгжүүлээгүй, 20573.8 мянган төгрөгийн үнэтэй Аксент маркын суудлын авто машиныг шууд данснаас хассан байсан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл. Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах 4/ ашиглах хугацаа дуусаагүй боловч осол, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг

Төрийн өмчийн хорооны зөвшөөрөлтэйгээр энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх; Аймгийн ИТХТ-ийн 2016.12.22-ний өдрийн 66-р тогтоолын 2-р хавсралтаар 20573.8 мянган төгрөгийн үнэтэй Аксент маркын суудлын авто машиныг худалдах доод үнийг 1000.0 мянган төгрөгөөр тооцсон зэргийг хэрэгжүүлээгүй

Шийдвэрлэсэн: Уг тээврийн хэрэгслийг дуудлага худалдаа сонгон шалгаруулалт явагдсаны дараа дуудлага худалдааны үнийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэний дараа данснаас хасахаар шийдвэрлэн залруулав

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

6. Аймгийн ИТХТ-ийн 2016.12.22-ний өдрийн 66-р тогтоолын 2-р хавсралтаар тус байгууллагын 155 нэр төрлийн 50757.8 мянган төгрөгийн хөрөнгийг актлахаас шийдвэрлэснийг данснаас хассан ба данснаас хасагдаж актлагдсан хөрөнгийг устгаагүй зөрчил илэрсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31-р зүйлийн 1-д Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Байгууллагын даргаын шийдвэрээр устгалын комисс томилон актлагдаж данснаас хасагдсан хөрөнгийг устгах ба устгалаас эргэж ашиглах боломжтой хөрөнгийг тогтоож шийдвэрлэх зөвлөмж өгөв.

7. Аудитын явцад тооллогын бүртгэл тооцоо бодсон актыг шалгахад тооллогын комиссын дүгнэлт тайлангаар 2 нэр төрлийн 2013.0 мянган төгрөгийн хөрөнгө СХААлбанд балансаас балансад шилжүүлсэн боловч шийдвэр гараагүй тул бүртгэлтэй байгаа 7 нэр төрлийн 5219.7 мянган төгрөгийн хөрөнгө давхар орлогдсон бүртгэлтэй байна гэжээ. Тооллогоор байхгүй 5219.7 мянган төгрөгийн хөрөнгийг 2011 онд давхардуулан бүртгэсэн гэснийг нотлох боломжгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл. Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах 4/ ашиглах хугацаа дуусаагүй боловч осол, гэмтлийн улмаас ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг Төрийн өмчийн хорооны зөвшөөрөлтэйгээр энэ зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэх; НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Тооллогоор дутагдсан 5219.7 мянган төгрөгийн хөрөнгийг Тооллогын комисс, өмч хамгаалах зөвлөл нь уг хөрөнгийг 2011 онд давхар бүртгэгдсэн гэж дүгнэсэн байгааг нотлох баримтаар албажуулан эрх бүхий байгууллагад хүргүүлэн данснаас хасах талаар зөвлөмж өгөв

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад 31445.1 мянган төгрөгийн материаллаг алдаа залруулагдсан. Материаллаг бус алдаа зөрчил нь зарцуулагдах боломжгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитаар өгөгдсөн аймгийн ИТХ-ын шийдвэрээр данснаас хасагдсан хөрөнгийг устгалыг болон ҮХ дансанд давхардсан хөрөнгийн нотлох баримтыг бүрдүүлэн холбогдох байгууллагад хүсэлт гарган шийдвэрлүүлсэн зэргийг хянахаар шийдвэрлэв.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын урсгал төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг хэмжээний 40292.7 мянган төгрөгийн, материаллаг бус 55977.5 мянган төгрөгийн буюу нийт 96270.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.Үүнд:

1. Материаллаг хэмжээний нийт 40292.7 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 31445.1 мянган төгрөгийн алдааг залруулсан ба 6543.3 мянган төгрөгийг алдааг таслан зогсоох зөвлөмж, 120.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт, 2184.3 мянган төгрөгийн алдаа залруулагдах боломжгүй ба МХЕГазраас тайлбар ирүүлсэн.
2. Материаллаг бус 55977.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Мэргэжлийн хяналтын газрын 2015 оны санхүүгийн тайланд Төв аймгийн Аудитын газраас хийсэн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд үндсэн хөрөнгийн тайланг няраваар гаргуулах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшин 11070.9 мянган төгрөгнөөс материаллаг хэмжээний залруулагдаагүй алдаа нь хэтрээгүй тул зөрчилгүй санал дүгнэлт өгөв.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ

2017 оны 02 сарын 22